



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар A/253

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 09/02 дугаар тогтоолоор батлагдсан “Аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 3.4.6, аймгийн “2019 оны төсөв батлах тухай” 2018 оны 09/10 дугаар тогтоолын 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтанг бэлтгэх, ажлын байранд зуучлах, мэргэжлийн боловсролын байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор “Элсэлт-сургалт-төгсөлт-ажлын байр” аймгийн зөвлөгөөнийг зохион байгуулсугай.

2. Дээрх арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах 1000000 (нэг сая) төгрөгийг аймгийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100539